

## **ХАА-н тооллого явуулсан тухай**

ХАА-н тооллогыг 1945 онд анх эхэлсэн ба түүнээс хойш нэлээд оронд 10 жилийн давтамжтайгаар олон улсад НҮБ-ын төрөлжсөн байгууллагын заавар аргачлалын дагуу тооллогоо явуулсаар ирсэн билээ. Монголд анх удаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу энэхүү тооллогыг явуулсан нь онцлог юм.

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3,7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Засгийн газрын 2012 оны 137 дугаар тогтоолыг үндэслэн Хөдөө аж ахуйн тооллогыг 5 дугаар сарын 15-аас 6 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж явууллаа.

ХАА-н тооллогод нэлэнхүй болон түүвэр судалгааны аргыг хослуулан хэрэглэсэн.

Газар тариалангийн тооллогод – газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг 1179 өрх, 77 аж ахуйн нэгж, байгууллага, МАА, газар тариалан хослон эрхэлдэг 26 ААН, ойн аж ахуй эрхэлдэг 4 ААН-ийг бүрэн хамруулж нэлэнхүй аргаар тооллого явуулсан.

МАА-н тооллогод – 2011 онд тоологдсон малтай өрхийн 33,0 хувь буюу 4153 өрх, 8 ААН-ийг түүврийн аргаар сонгон хамруулсан.

Тооллогын үр дүнг нэгтгэх, хэвлэх, тараах үйл ажиллагаа 2012 оны ҮИ/15 – 2013 оны III/30 хүртэл үргэлжилнэ.

Энэхүү тооллогын үр дүнгээс төр засгийн бодлого боловсруулагч байгууллага, бусад хэрэглэгчдэд ХАА-н салбарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх боломжтой.

Тооллого зохион явуулах аймгийн ажлын хэсгийн сургалтыг зохион байгуулж тооллогын ажлын төлөвлөгөө, аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын удирдамж, тоологч шалгагчийн сургалтын хөтөлбөр, 5-р сарын 25-аас 6-р сарын 15-ний хооронд байнгын жижүүрлэх жижүүрийн хуваарь хэлэлцэж баталлаа. Шуурхай төлөвлөгөөний дагуу бүх ажил зохион байгуулагдсан.

Тооллогын асуулга маягтыг нөхөх тоологч, түүнийг шалгах шалгагч нарыг бэлтгэх сургалтыг аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд зохион байгуулж ХААТ-ын комиссын дарга З. Ганболд нээж хэлтэсийн ажилтнууд батлагдсан хуваарийн дагуу 2 өдөр сургалтаа хийж, сургалтанд 114 тоологч, 24 шалгагч нийт 138 хүн хамрагдлаа. 2 өдөр тоологч, шалгагчдаа бүрэн хичээлийг нь тасалдуулахгүй байхын тулд үдээс урагш хойш иршийн бүртгэл хөтөлсөн.

Сургалтаар ХААТ-ын ач холбогдол, хөдөө аж ахуйн тооллогын үзэл баримтлал, зохион байгуулалт, тоологч, шалгагчийн баримтлах зарчим, үүрэг, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн асуулга ХААТ-1А маягт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга ХААТ-1Б маягт, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн асуулга ХААТ-2А маягт, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга ХААТ-2Б маягт, мал, тэжээвэр амьтдын хагас жилийн тооллого ХААТ-3 маягт, ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга ХААТ-4А маягт, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын асуулга ХААТ-4Б маягт, загасны аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын

асуулга ХААТ-4В маягт, захиргааны анхан шатны нэгжийн асуулга ХААТ-5 маягтуудыг нөхөх заавар, тооллогын газрын зурагтай ажиллах талаар болон хагас жилийн мал тооллогын асуулга маягтыг шивэх програмын сургалт хийж аргачлал заавар маягтуудаа хувиарлаж өгсөн. Маягт тус бүрийн сургалт орсны дараа дадлагын ажил хийлгэж, чөлөөт ярилцлага зохион байгуулж хоёрдмол утгатай зарим асуулгуудын талаар ҮСХ-оос асууж тоологч, шалгагч нар нэгдмэл ойлголт авсан.

Тооллогын маягт, заавар, газрын зургийг ҮСХ-оос татан авах ажлыг шуурхай зохион байгуулж, улмаар сумдад хугацаанд нь хүргүүлж тооллогыг хугацаанд нь эхлүүлж 3 өдөр тутам явцын мэдээллийг авч ҮСХ-нд мэдээлэхээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тархаах, удирдлагуудад танилцуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авахыг санал болгох зэргээр тооллогын явц байдалд дүгнэлт хийж ажилласнаар 5447 нэгж тооллогод хамрагдахаас 5435 нэгж хамрагдаж хамралт 99.8 хувь болж хугацаандаа дуусах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа. / шилжсэн, нас барсан гэх мэт шалтгаантай 12 нэгж байлаа /

Тооллогоо алдаагүй, үнэн зөв, шуурхай хийхийн тулд сумдын төрийн сангийн төлөөлөгч болон ҮСХ-ны ажлын хэсгийнхэнтэй хариуцлагатай жижүүр, хэлтсийн ажилтнууд байнга холбоотой ажиллаа.

Нийт иргэдэд ХААТ-ын талаар мэдээлэл хийж төв орон нутгын телевизээр 4 , орон нутгийн сонинд 1 удаа ярилцлага өглөө.

Сумууд ХААТ-ын комиссын зүгээс өгсөн чиг үүргийн дагуу тоологч нар 6-р сарын 5-нд нэгж дээр тоолох ажлаа дуусгаж 6-р сарын 15 хүртэл сумдын шалгагч нар тоологчоосоо материалаа шалган хүлээн авч 15-наас эхлэн батлагдсан хуваарийн дагуу аймгийн тооллогын комисст хүлээлгэн өглөө.

Аймгийн статистикийн хэлтсийн үндсэн ажилтнууд шалгагчаар ажиллаж сумдын асуулгын маягтуудыг нэг бүрчлэн шалгаж ажлын цагаа уртасгасан хугацаатайгаар өдөр шөнөгүй 19 хоног ажиллаа. Тооллогын асуулгын 14 хайрцаг материалыг 7-р сарын 5-нд автобусаар, 19 сумын тооллогын комиссын газрын зургийг 7-р сарын 9-ний онгоцоор улаанбаатар хот руу ҮСХ-нд хүргүүлэхээр явуулаа.

### **Хагас жилийн малын тооллого :**

ХААТ-ын нэг болох хагас жилийн мал тооллогыг зарлагдсан тооллогын товын хугацаанд хийж дуусгалаа.

ХААТ-ын сургалтын үеэр төрийн сангийн төлөөлөгч нарт шивэлтийн программын сургалт хийж, программ хангамжуудыг ком-т суулган өгч дадлага ажил хийлгэж сургаж дадлагажууллаа.

Түүвэр тооллогод хамрагдсан өрхүүдийн оны эхний мал, хээлтэгч малын тоо, түүнчлэн сургалтын үеэр ком-гүй ирсэн сумдад бааз бүрдүүлэх программ хангамжийг CD – ээр бичиж өгсөн.

Тооллогын үед болон шивэлтийн явцад сумдуудтай байнга холбоотой байж, байнгын заавар зөвлөмжөөр хангаж ажилласан бөгөөд 4.1 мянган өрхийн мэдээллийн бааз бүрдүүлж хугацаанд нь ҮСХ-нд хүргүүлээ.

Өндөрхангай сумын төрийн сангийн төлөөлөгч Д.Баянцэцэгээс хорогдол гэнэт яагаад өссөн шалтгааныг тодруулахад: 4-р сарын 20-оос 5-р сарын 10 хооронд цас их орсоны улмаас Цагааннуур, Жаргалант, Батсайхан багийн малчин өрхийн 5000 гаруй мал зүй бусаар хорогдсон гэж тайлбар өгсөн.

### **Хяналт шалгалт:**

Аймгийн тооллогын комиссын даргаар батлуулсан удирдамж, хуваарийн дагуу Улаангом, Давст, Сагил, Тариалан сумдад буюу нийт сумдын 21.9 хувьд нь хяналт хийлээ. Энэхүү хяналтын мөрөөр нийтлэг гаргаж буй алдаа, хойшид анхаарах асуудлаар албан тоот үйлдэж бүх сумдад төрийн сангийн сүлжээг ашиглан яаралтай хүргүүлэн мөрдүүлсэн. Шалгалтын үеэр зарим тоологчид асуулгын маягтны зарим асуултыг асуухгүй орхигдуулах, насаа буруу тооцох, гар зурган дээрээ өрхийн байрлалтаар тэмдэглэх, сумын тооллогын комиссын зурган дээр ажиллахдаа тооллогын асуулгын дугаараар тэмдэглэх зэрэг алдаа гаргаж байсныг хэлж ойлгуулан залруулсан. Улаангом сумын ажлын хэсгийнхэнтэй тооллогын явцын үед өдөр бүр уулзан хяналт хийж цаг тухайд нь заавар зөвлөмж өгч байсан.

### **Хүндрэл бэрхшээл, хойшид анхаарах санал:**

Тооллогын эхний 2 өдөр Цагаанхайрхан, Баруунтуруун, Хяргас, Өндөрхангай, Зүүнхангай зэрэг уулархаг хангайн сумдаар битүү их хэмжээний цас унасан нь тооллогын ажилд зам харгуйн боогдох зэргээр хүндрэл учирч тооллогын явц удааширсан.

Тооллогод ажлын дадлага туршлагатай урд өмнөх ХАОС-ны тооллого, ААН-ын тооллогод оролцож байсан хүмүүсийг энэ удаагийн тооллогод тоологчоор ажиллуулахыг хичээсэн. Тооллого Улсын Их Хурлын сонгуулийн бэлтгэл ажлын хугацаатай давхцсан учраас зарим тоологч шалгагч нарт ажлын ачаалал хүндрэл бэрхшээл ихээхэн тулгарсан байна. Суманд хэдхэн тооны чадварлаг төрийн албаны хүмүүс ажилладаг тэдгээр нь ямар л ажил сумын хэмжээнд зохион байгуулагдана тэр бүгдэд дайчлагдаж байдаг тул зарим тоологч шалгагч сонгуулын хэсгийн хороо болон сумын сонгуулын хороонд ажилласан байна. Хойшид Улсын хэмжээгээр томоохон салбарын тэр дундаа 10 жил тутамд хийгддэг тооллогыг улсын хэмжээнд хийгдэж байгаа өөр ажилтай цаг хугацааг нь давхцууламгүй байна.

Тооллогын зарим маягтанд хоёрдмол утгатай асуулга байгаа тул хойшид энэ тал дээр сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна.